

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/192-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
---------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. Аудитын тайлан	15-17
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19-20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.08.25 № СЭА-2023/192-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН 8 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Т.НАМИРАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 96.5 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 3.5 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 71.6 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 10.8 хувийг нормативт зардал тус тус эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

СЭА-2023/192-НА-СТА-ТШЗ

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,160,149.3	59,569,233.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	18,388,708.9
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	18,388,708.9
31210	Төгрөг	-	18,388,708.9
31211	Төрийн сангийн харилцах	-	18,388,708.9
35	БАРАА МАТЕРИАЛ	33,160,149.3	41,180,524.3
35100	Түүхий эд материал	27,546,859.3	28,046,859.3
35110	Тусгай зориулалттай материал	27,546,859.3	28,046,859.3
35400	Хангамжийн материал	5,613,290.0	13,133,665.0
35410	Бичиг хэргийн материал	139,500.0	551,100.0
35420	Аж ахуйн материал	3,868,900.0	5,336,850.0
35460	Хүнсний материал	1,604,890.0	1,182,065.0
35470	Бусад хангамжийн материал	-	6,063,650.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,400,839,805.8	1,388,781,791.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,400,839,805.8	1,388,781,791.2
39200	Биет хөрөнгө	1,365,460,805.8	1,353,501,791.2
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,322,764,382.0	1,322,764,382.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,997,669.9)	(37,452,957.5)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	35,625,350.0	41,905,762.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,476,738.3)	(7,593,905.0)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,709,729.7	21,513,729.7
39208	Хуримтлагдсан элэгдэл	(164,247.8)	(2,135,221.0)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	14,500,000.0
39300	Биет бус хөрөнгө	35,379,000.0	35,280,000.0
39301	Програм хангамж	495,000.0	495,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(99,000.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	34,884,000.0	34,884,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,433,999,955.1	1,448,351,024.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,433,999,955.1	1,448,351,024.4
51	Засгийн газрын хувь оролцоо	1,433,999,955.1	1,448,351,024.4
51200	Хуримтлагдсан үр дүн	1,433,999,955.1	1,448,351,024.4
51210	Өмнөх үеийн үр дүн	1,433,999,955.1	34,642,427.5
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,413,708,596.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,433,999,955.1	1,448,351,024.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны үзүүлэлт	Тайлант оны үзүүлэлт
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,609,401,157.0	1,951,337,814.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,413,163,203.0	1,425,814,540.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,413,163,203.0	1,425,814,540.5
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,400,759,461.7	1,386,977,791.2
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	12,403,741.3	38,836,749.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,573,654.0	525,523,273.7
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,000,000.0	423,186,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,000,000.0	423,186,000.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	147,664,300.0	0.0

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	188,000.0	0.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	188,000.0	0.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,385,654.0	102,337,273.7
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,385,654.0	102,337,273.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	175,401,201.9	537,629,217.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	175,401,201.9	537,629,217.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	163,525,286.9	537,629,217.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,737,741.0	323,299,116.7
210101	Үндсэн цалин	66,975,412.0	245,707,151.9
210102	Нэмэгдэл	20,231,803.0	71,341,601.8
210104	Урамшуулал	9,530,526.0	6,250,363.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,993,553.0	39,673,239.6
210201	Тэтгэврийн даатгал	8,155,602.0	27,312,381.0
210202	Тэтгэмжийн даатгал	959,490.0	3,181,713.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	767,580.0	2,545,490.2
210204	Ажилгүйдлийн даатгал	191,900.0	601,209.9
210205	Эрүүл мэндийн даатгал	1,918,981.0	6,032,444.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,885,654.0	58,584,908.4
210301	Гэрэл, цахилгаан	2,650,357.0	7,962,248.4
210302	Түлш, халаалт	22,977,758.0	43,335,544.0
210303	Цэвэр, бохир ус	1,257,539.0	7,287,116.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,348,782.0	0.0
210401	Бичиг хэрэг	199,500.0	0.0
210402	Тээвэр, шатахуун	50,000.0	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.0	0.0
210404	Ном, хэвлэл	60,000.0	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	345,032.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	514,250.0	0.0
2105	Нормативт зардал	13,481,201.0	55,172,925.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,000.0	0.0
210502	Хоол, хүнс	13,441,201.0	55,172,925.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	17,292,450.0
210604	Урсгал засвар	0.00	17,292,450.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	349,600.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	349,600.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,078,355.9	43,256,977.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	7,328,600.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	439,700.0	1,285,950.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,638,655.9	34,642,427.5
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,875,915.0	0.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,875,915.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,433,999,955.1	1,413,708,596.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,433,999,955.1	1,413,708,596.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны үзүүлэлт	Тайлант оны үзүүлэлт
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	196,237,954.0	525,523,273.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,237,954.0	525,523,273.7
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,000,000.0	423,186,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,000,000.0	423,186,000.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	147,664,300.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	188,000.0	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	188,000.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,385,654.0	102,337,273.7
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,385,654.0	102,337,273.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	183,518,954.0	505,330,564.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	183,518,954.0	505,330,564.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	171,643,039.0	505,330,564.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,737,741.0	323,299,116.7
210101	Үндсэн цалин	66,975,412.0	245,707,151.9
210102	Нэмэгдэл	20,231,803.0	71,341,601.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	9,530,526.0	6,250,363.0
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,993,553.0	39,673,239.6
210201	Тэтгэврийн даатгал	8,155,602.0	27,312,381.1
210202	Тэтгэмжийн даатгал	959,490.0	3,181,713.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	767,580.0	2,545,490.2
210204	Ажилгүйдлийн даатгал	191,900.0	601,209.9
210205	Эрүүл мэндийн даатгал	1,918,981.0	6,032,444.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,885,654.0	58,584,908.4
210301	Гэрэл, цахилгаан	2,650,357.0	7,962,248.4
210302	Түлш, халаалт	22,977,758.0	43,335,544.0
210303	Цэвэр, бохир ус	1,257,539.0	7,287,116.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,064,000.0	-
210401	Бичиг хэрэг	216,000.0	-
210402	Тээвэр, шатахуун	50,000.0	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.0	-
210404	Ном, хэвлэл	60,000.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	308,000.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,250,000.0	-
2105	Нормативт зардал	27,907,091.0	54,750,100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,000.0	-
210502	Хоол, хүнс	15,046,091.0	54,750,100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,821,000.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,255,000.0	15,500,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	470,000.0	-
210604	Урсгал засвар	3,785,000.0	15,500,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	961,600.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	961,600.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.0	12,561,600.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,070,600.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.0	4,491,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,875,915.0	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,875,915.0	-

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	12,719,000.0	20,192,708.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	12,719,000.0	1,804,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,719,000.0	1,804,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	12,719,000.0	1,804,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,719,000.0	1,804,000.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(12,719,000.0)	(1,804,000.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	18,388,708.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,388,708.9

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	34,642,427.5	34,642,427.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	34,642,427.5	34,642,427.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,413,708,596.9	1,413,708,596.9
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,448,351,024.4	1,448,351,024.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	525,523,400.0	507,134,564.7	18,388,835.3	96.5
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	525,523,400.0	507,134,564.7	18,388,835.3	96.5
210	Бараа, үйлчилгээний зардал	525,523,400.0	507,134,564.7	18,388,835.3	96.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,863,100.0	323,299,116.7	2,563,983.3	99.2
210101	Үндсэн цалин	264,789,500.0	245,707,151.9	19,082,348.1	92.8
210102	Нэмэгдэл	55,323,200.0	71,341,601.8	(16,018,401.8)	129.0
210104	Урамшуулал	5,750,400.0	6,250,363.0	(499,963.0)	108.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,511,500.0	39,673,239.6	838,260.4	97.9
210201	Тэтгэврийн даатгал	27,678,300.0	27,312,381.1	365,918.9	98.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,212,400.0	3,181,713.7	30,686.3	99.0
210203	ҮОМШӨ ний даатгал	2,570,000.0	2,545,490.2	24,509.8	99.0
210204	Ажилгүйдлийн даатгал	640,600.0	601,209.9	39,390.1	93.9
210205	Эрүүл мэндийн даатгал	6,410,200.0	6,032,444.8	377,755.2	94.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,585,000.0	58,584,908.4	91.6	100.0
210301	Гэрэл цахилгаан	7,962,300.0	7,962,248.4	51.6	100.0
210302	Түлш, халаалт	43,335,600.0	43,335,544.0	56.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	7,287,100.0	7,287,116.0	(16.0)	100.0
2105	Нормативт зардал	69,698,200.0	54,750,100.0	14,948,100.0	78.6
210502	Хоол, хүнс	69,698,200.0	54,750,100.0	14,948,100.0	78.6
2106	Эд хогшил худалдан авах	15,500,000.0	15,500,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	15,500,000.0	15,500,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	962,000.0	961,600.0	400.0	100.0
210806	Мэдээллийн технологийн зардал	962,000.0	961,600.0	400.0	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	14,403,600.0	14,365,600.0	38,000.0	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,903,600.0	9,874,600.0	29,000.0	99.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.0	4,491,000.0	9,000.0	99.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	525,523,273.7	(525,523,273.7)	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	423,186,000.0	(423,186,000.0)	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	423,186,000.0	(423,186,000.0)	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	102,337,273.7	(102,337,273.7)	-
132001	Орон нутгийн төсвөөс	-	102,337,273.7	(102,337,273.7)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,388,708.9	(18,388,708.9)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.0	28.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.0	16.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	11.0	11.0	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэг /Цаашид Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэг гэх/ нь “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- СӨБ- үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн хүүхэд нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулах,
- Эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч хүүхдийг бий болгон төлөвшүүлэхэд анхаарч ажиллах,
- Үндэс язгуур, төрт ёс, өв соёлоо дээдлэх ухааныг зааж сургах,
- Цэцэрлэгийн хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын хэмжээг үндэслэн жил бүр шинэчлэн тогтоох,
- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдлыг тооцон сургалтыг чанартай зохион байгуулахад чиглэсэн тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтнийг ажиллуулах,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батдагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан

хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,

- *БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,*
- *ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,351.0 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	18,388.8	18,388.8
Авлага	-	-	-
Бараа материал	33,160.1	41,180.4	8,020.3
Үндсэн хөрөнгө	1,400,839.8	1,388,781.8	(12,058.0)
Нийт хөрөнгө	1,434,000.0	1,448,351.0	14,351.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,434,000.0	1,448,351.0	14,351.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,434,000.0	1,448,351.0	14,351.0

Тайлант оны үйл ажиллагааны зардлын хэмнэлт 18,388.7 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 41,180.4 мянган төгрөг болж 8,020.3 мянган төгрөгөөр өссөн байгаа нь төсвийн хөрөнгөөр 79,075.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, аймгийн БШУГ-аас 103.5 мянган төгрөгийн бараа материал, УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатаас 5,573.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан болон 76,732.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,436,062.9 мянган төгрөг болж 22,584.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,804.0 мянган төгрөгийн тавилга худалдан авсан, БНСУ-ын Жэжү мужийн Боловсролын газраас 6,280.4 мянган төгрөгийн суурин компьютер, УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатаас 14,500.0 мянган төгрөгийн гадна талбайн тоглоом, хиймэл зүлгийг үнэ төлбөргүй хүлээн авч, бүртгэл тайланд тусгаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,448,351.0 мянган төгрөг болж 14,351.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэг нь 2021 оны 9 дүгээр сард үйл ажиллагаагаа эхэлсэн тул 2022 оны төсвийн төсөл боловсруулж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлээгүй байна.

2022 оны төсвийг 437,762.6 мянган төгрөгөөр тооцож баталснаас тайлант онд хийгдсэн төсвийн зохицуулалтаар цалингийн зардлыг 55,150.4 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6,738.4 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 23,848.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,023.6 мянган төгрөгөөр тус тус нэмснээр 525,523.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 423,186.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 102,337.4 мянган төгрөг, нийт 525,523.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 507,134.6 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 2,564.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 838.3 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 14,948.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, 18,388.8 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасанатай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/							
Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,300.0	1,300.0	-	100.0
		2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	69,698.2	54,750.1	14,948.1	78.6
		3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,023.6	2,023.6	-	100.0
		4	81823-Боловсролын байгууллагын багш	1,300.0	1,288.0	0.1	99.1
		5	81834-Боловсролын стандарт сургалт	295,602.3	293,257.9	2,344.4	99.2
		6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	53,261.9	52,177.7	1,084.2	98.0
		7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	74,085.0	74,085.0	-	100.0
		8	80112-Нийтлэг үйлчилгээ	28,252.4	28,252.4	-	100.0
Нийт				525,523.4	507,134.6	18,388.8	96.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримтын бүрдэл, төлбөрийн цахим баримт болон санхүүгийн тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 407,930.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,079.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Сүхбаатар сумын 8 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- *Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, үдийн цай хөтөлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр нийт 18,388.7 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.*
- *Баяр ёслол, тэмдэглэлт өдөр, аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй,*

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 21 төрлийн 173 мэдээллээс 1 мэдээллийг огт мэдээлээгүй ба 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ – 2 удаа
- Дараа жилийн зорилтот түвшин – 2 удаа
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг – 1 удаа
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга, хэмжээний тайлан – 1 удаа
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт – 1 удаа
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн – 1 удаа

Шийдвэрлэсэн нь: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд хуулийн хугацаанд мэдээлж байх зөвлөмж хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулаагүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д *“Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ”*, 48.5-т *“Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”* гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон зөвлөмж өгөгдсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг аудитаар дахин хянахад 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	1	-	1	-	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудал нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус бараа үйлчилгээний бусад зардалд бөөнөөр нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлыг бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

2. Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт,

санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Цаашид БШУЯ-ны төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар үндсэн хөрөнгийн шинж чанартай 5,082.0 мянган төгрөгийн 4 нэр төрлийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн болон 2 үндсэн хөрөнгөд 1,691.7 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй, бичиг хэргийн материалын үлдэгдлийг 50.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан зэрэг нийт **6,824.2** мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 11,713.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 829.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 10,883.7 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1.1 Илрүүлэлт: Сургалт зохион байгуулах гэрээ зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр, цэцэрлэгийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр бус “Хууль зүйн зөвлөгөө”, “ХАБЭА”-ын чиглэлээр “Төгс баян хүрээ” ХХК болон иргэн А.Мөнхтуяа нарын зохион байгуулсан сургалтад 7 албан хаагчийг хамруулан 480.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийг хичээл, сургалтын зардлаас төлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2.1 Илрүүлэлт: Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас шуудан, холбооны төлбөр төлөхөд 349.6 мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын “210806: Мэдээлэл, технологийн үйлчилгээ – Хамаарахгүй зүйлс: Шуудангийн үйлчилгээ, интернэтийн төлбөр, телефон утас яриатай холбоотой гарсан зардал” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2 Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд нийт 10,753.7 мянган төгрөгийн хүнс, урсгал засварын материалын худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталгаажуулсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “ ... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх.

2. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудасгүй, зарцуулалтыг нотлох баримтгүйгээр тооцож 130.0 мянган төгрөгийн шатахуун олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Цаашид шатахууны зарцуулсан тус бүрээр анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

3. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн	1	5,082.0			1	5,082.0	1	5,082.0				
Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцоогүй	1	1,691.7	1	1,691.7			1	1,691.7				
Дансны үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан.	1	50.5			1	50.5	1	50.5				
Дүн	3	6,824.2	1	1,691.7	2	5,132.5	3	6,824.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй.	1	480.0			1	480.0						
Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй.	1	349.6			1	349.6						
Төлбөрийн цахим баримтыг бөөн дүнгээр баталгаажуулсан.	1	10,753.7					1	10,753.7				
Шатахууны зарцуулалтыг анхан шатны баримтаар баталгаажуулаагүй.	1	130.0					1	130.0				
Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй	1	-					1	-				
Дүн	5	11,713.3			2	829.6	3	10,883.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 1 мэдээлэл мэдээлээгүй, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулаагүй.	1						1	-
Нийт дүн	2	-					2	-